



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ДҮҮРГИЙН АВТО МАШИНЫ ТОО



Улаанбаатар  
2019 он



2018 оны техникийн хяналтын үлсын үзлэгт Хан-Уул дүүргийн 44757 тээврийн хэрэгсэл хамрагдаж, өнгөрсөн оныхоос 6803 тээврийн хэрэгслээр нэмэгджээ.

Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй автомашины тоо сүүлийн 3 жилд дунджаар 11.5 хувиар өсчээ. Тухайлбал, 2016 онд 6.5 хувиар, 2017 онд 10.2 хувиар, 2018 онд 17.9 хувиар өмнөх оныхоос тус тус өссөн байна.

Нийслэлийн хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 11.1 хувийг Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Хүснэгт 1. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины тоо, төрлөөр

	2016	2017	2018	Автомашины тоо, төрлөөр				Амины автомашин	
				Сүүдлын	Ачааны	Автобус	Тусгай	2017	2018
Нийслэлийн дүн	339626	365819	401725	309812	75256	10301	6356	294472	326290
Хан-Уул дүүрэг	34444	37954	44757	35666	6937	1312	842	29077	33883

2018 онд дүүргийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт 44757 тээврийн хэрэгслийн 79.7 хувийг сүүдлын автомашин эзэлж байгаа бол 15.5 хувь нь ачааны, 2.9 хувь нь автобус, 1.9 хувь нь тусгай зориулалтын автомашин тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Автомашины тоо, ашиглалтын хугацаагаар

	2017				2018			
	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш
Нийслэлийн дүн	365819	8706	82861	274252	401725	10296	94257	297172
Хан-Уул дүүрэг	37954	2746	10025	25183	44757	3701	12650	28406

2018 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн нийт тээврийн хэрэгслийн ихэнх буюу 63.5 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд эзэлж байна. Улаанбаатар хотод техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 297.2 мянган (74.0 %) тээврийн хэрэгсэл нь арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд байна. Үйлдвэрлэгдэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил ашиглаж буй шинэ автомашины тоо дүүргийн хэмжээнд нийт тээврийн хэрэгслийн 8.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 1.1 пунктээр өссөн дүнтэй байна.

Хүснэгт 3. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018
Нийт орлого	сая.төг	917.4	1979.5
Зорчигчдын тоо	мян.хүн	1528.3	461.3
Зорчигч эргэлт	мян.хүн.км	5196.2	1568.4

Дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2018 онд 1568.4 мянган хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 461.3 мянган хүн тээвэрлэж, 1979.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Зорчигчдын тоо өмнөх оныхоос 1067.0 мянган хүнээр (69.8%) буурч, үйлчилгээний орлого 1062.1 сая төгрөгөөр (2.1 дахин) нэмэгдсэн байна. Зорчигчдын тоо, зорчигч эргэлтийн бууралтад зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж нь автобусныхаа тоог багасгасан нь нөлөөлж, орлогын өсөлтөд тээвэр зуучлалын компанийн орлого нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 4. Автомашины тоо, хөдөлгүүрийн шатахууны төрлөөр

Үзүүлэлт	Үүнээс: автомашин үндсэн төрлөөр									
	Бүгд		суудлын		ачааны		автобус		тусгай зориулалт	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Нийт дүн	37954	44757	29367	35666	6386	6937	1370	1312	831	842
Бензин	17801	20073	17115	19413	343	389	308	229	35	42
Дизель	9877	10809	2174	2482	5932	6505	998	1022	773	800
Хосолсон	8721	12289	8610	12220	51	20	48	49	12	-
Газ	1555	1586	1468	1551	60	23	16	12	11	-

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн 44.7 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь шатахууны төрлөөр ангилж үзэхэд 44.8 хувийг нь бензин хөдөлгүүртэй автомашин эзэлж, энэ төрлийн автомашины тоо 2017 оноос 12.8 хувиар өссөн байна. Дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 24.1 хувийг, хосолсон хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 27.5 хувийг, газ хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл 3.5 хувийг эзэлж байна.

Танилцуулга бичсэн:

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунгэрэл